



УЛС ТӨРИЙН НАМУУДАД

**МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж 11, Засгийн газрын XI байр,
Утас: 26 09 75, Факс: (976-11) 32 69 75,
И-мэйл: gecst@gec.gov.mn, Вэбсайт: www.gec.gov.mn

2020.03.13 № 1/69
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаатай холбогдуулан Улсын онцгой комиссын 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 10 дугаар хуралдаанаар Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоолоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, Улсын онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1 дүгээр хурлын шийдвэрээр олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хязгаарласан тул улс төрийн намууд Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийг мөрдөж ажиллахыг чиглэл болгосон байна.

Иймд Улсын онцгой комиссоос 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан улс төрийн намуудын удирдлагуудтай хийсэн уулзалт дээр сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэлэлцэх үйл ажиллагааг цахим хэлбэрээр хийх нь зүйтэй гэж зөвлөсний дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана уу.

Хүндэтгэсэн,

ДАРГА *Ч. Содном* Ч.СОДНОМЦЭРЭН





УЛСЫН ОНЦГОЙ КОМИСС

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Партизаны гудамж 6, Утас: 26-21-26, Факс: 26-35-54
E-mail: uok@nema.gov.mn

2020.03.13 № 90

танай _____ -ны № _____ - т

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ
ХОРООНЫ ДАРГА
Ч.СОДНОМЦЭРЭН ТАНАА

Чиглэл хүргүүлэх тухай

Коронавируст халдвар өндөр хурдацтайгаар тархаж, дэлхийн 116 улсад 133,977 гаруй хүн өвчилж, 4,964 хүн нас барсан (2020 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар)

Коронавируст халдварын анхны тохиолдол манай улсад 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдөр бүртгэгдсэн. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдөр коронавируст халдвар “Цар тахалын шинжтэй” болсоныг зарласан болно.

Засгийн газар, Улсын онцгой комиссоос коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг шат дараалан шуурхай авч хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- Хилийн боомтуудыг хаах;
- Улс, хот хоорондын зорчигч тээвэр (авто болон төмөр зам, нислэг)-ийн хөдөлгөөнийг зогсоох;
- Бүх шатны боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг зогсоох;
- Үйлчилгээний байгууллагуудын цагийн хуваарьт өөрчлөлт оруулж хязгаарлах;
- Шашны байгууллагуудын үйл ажиллагааг хязгаарлаж, төрөл бүрийн хурал, цуглаан, уулзалт, семинар зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээг хориглох;
- Цагаан сарын баяр, Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр, Наурызын баяр, Монгол цэргийн өдөр зэрэг баяр, тэмдэглэлт өдрүүдийг хязгаарлагдмал хүрээнд тэмдэглэн өнгөрүүлэх зэрэг хатуу чанд арга хэмжээг авч хэрэгжүүлснээр Монгол Улсын иргэн коронавируст халдвараар өвчлөөгүй байна.

Засгийн газар, Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлж байгаа дээрх арга хэмжээг иргэд, олон нийт дэмжиж байгаа бөгөөд судалгаагаар иргэдийн 80 гаруй хувь нь Засгийн газрын үйл ажиллагааг зөв зүйтэй гэж үзжээ.


Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажилтай холбогдуулан улс төрийн намуудаас тавьсан санал, хүсэлтийг Улсын онцгой комиссын 2020 оны 3

00000021

дугаар сарын 10-ны өдрийн 10 дугаар хуралдаанаар хэлэлцээд Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоолоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, Улсын онцгой комиссын 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 1 дүгээр хурлын шийдвэрээр олон нийтийг хамарсан төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулахыг хязгаарласан тул Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийг шуурхай мөрдөж ажиллахыг дахин сануулах нь зүйтэй хэмээн шийдвэрлэсэн болно.

Иймд улс төрийн нам, эвслүүд үндэсний эв нэгдэл, нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ гэдэгт итгэж байна.

ДАРГА,
ШАДАР САЙД



Ө.ЭНХТҮВШИН